



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

9/08 оны 03 сарын 24-ны өдөр

Дутаар Ч.Мөнхбат

Мандалын

Аймгийн 2021-2024 оны Стратеги  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмын"-ын 2.1, 2.2, 2.3, 3.1 дэх заалтууд аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг орон нутагт оновчтой зохион байгуулах зорилгоор ажлын хэсгийн боловсруулсан "Аймгийн 2021-2024 оны Стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Аймаг болон салбарын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд тус бүр чиг үүргийн дагуу стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулахад шаардлагдах зардлыг жил бурийн төсөвтөө тусган, явцын үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг төсвийн шууд захирагч, сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2 жил тутамд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар



ДУНДГОВЬ АЙМГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2021-2024/

## **АГУУЛГА**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	1-3
2. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ .....	4-18
3. АЛСЫН ХАРАА .....	19
4. ЭРХЭМ ЗОРИЛГО .....	19
5. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО .....	19
6. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ .....	20-67
7. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ .....	68-69
8. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ 2021- 2024 .....	70-113
9. ХАВСРАЛТ .....	114-151

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна”, 53.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөөг боловруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална” гэж заасны дагуу Монгол улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу “Дундговь аймгийн стратеги төлөвлөгөө”-г боловсрууллаа.

Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, , Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах заавар” зэрэг эрх зүйн баримт бичигт үндэслэн 2015-2018 онд “Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 93 дугаар тушаал нь Сангийн сайдын 2017 оны 13 дугаар тушаалаар хүчингүй болсон тул 2019 оноос хойш аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулаагүй байна.

2015-2018 онд байгууллагын стратеги төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлсэн байна.

2015-2018 онд аймгийн дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргаас Засаг даргын Тамгын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг он тус бүрээр авч үзвэл:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2015 онд 85,5%, 2016 онд 89,2%, 2017 онд 92,7%, 2018 онд 90,3%,
2. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 2015 онд 88,7%, 2016 онд 87,8%, 2017 онд 91,2%, 2018 онд 91,9%,
3. Аймгийн Засаг даргаас Засаг даргын Тамгын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилт 2015 онд 87,1%, 2016 онд 89,2%, 2017 онд 90,5%, 2018 онд 90,1%

Дээрх үр дүнгээс харахад 2015-2018 оны байгууллагын стратеги зорилт, арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн, боловч цаашид төлөвлөлт, удирдлага арга зүй, зохион байгуулалтыг сайжруулах, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх, зорилт, арга хэмжээ бүрийг оновчтой тодорхойлон, шалгуур үзүүлэлт бүрийг хангаж ажиллах хэрэгцээ, шаардлага байгааг харуулж байна.

Мөн Монгол улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиуд шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиг үүргийн хүрээнд орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг ханган ажиллах нөхцөл бий болоод байна.

Дундговь аймгийн стратеги төлөвлөгөөг Дундговь аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг дарын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан 55 зорилтыг дэвшүүлж, эдгээр зорилтыг хэрэгжүүлэх 216 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцох нь төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэх, ард иргэдийн санал, санаачлага, оролцоонд тулгуурлан орон нутгийн эрх ашиг, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулахад чухал ач холбогдолтой гэж үзсэн.

### **Аймгийн өнөөгийн нөхцөл байдал**

Дундговь аймаг нь 1941 онд одоогийн Өлзийт сумын нутаг Ембүү Дээрсэнэ ус гэдэг газар Шарангад нэртэйгээр байгуулагдаж, 1942 онд аймгийн нэрийг Дундговь хэмээн өөрчилж аймгийн төв одоогийн оршин байгаа Зоогийн хар овооны энгэрт суурьшсан байна. Засаг захиргааны нэгжийн хувьд 15 сүм, 68 багийн иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна.

Дундговь аймаг нь 7,469, 032 мянган га газар нутагтай, үүнээс хөдөө аж ахуйн эдэлбэр газар 7,129,295,7 мянган га, хот суурин газар 17,732,3 мянган га, зам, шугам сүлжээ 30,555,4 мянган га, усан сан бүхий газар 7,796,0 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 224,465,0 мянган га газрыг тус тус эзэлдэг.

2020 оны жилийн эцсийн байдлаар Дундговь аймаг 47274 хүнтэй болж, үүнээс эрэгтэй 23796 буюу 50,3,, эмэгтэй 23478 буюу 49,7% байна. Өмнөх онтой харьцуулбал хүн ам 837 буюу 1.8 хувиар өссөн. Нийт хүн амын 50.3 хувийг эрэгтэйчүүд, 49.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Мөн 10969 буюу 23.2 хувийг 0- 14 насны хүүхэд, 34674 буюу 73.3 хувийг 15-64 насны хүмүүс, 1631 буюу 3.5 хувийг 65 ба түүнээс дээш насны хүмүүс эзэлж байна. Насны бүлгээс харахад 70 ба түүнээс дээш настан 1630, 80 ба түүнээс дээш настан 634, 90 ба түүнээс дээш настан 82, 100 ба түүнээс дээш настан 1 хүн бүртгэгдсэн байна.

Хүн амыг суурьшилаар нь авч үзвэл аймгийн төв Мандалговь хотод 15999 иргэн , хөдөөгийн 14 суманд 31275 иргэн оршин сууж байна. Аймгийн хэмжээнд 14457 өрхтэй. Үүнээс аймгийн төв Мандалговь хотод 4779 өрх , хөдөөгийн 14 суманд 9678 өрхтэй байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 3,741,0 мянган толгой мал тоологдсоноос адuu 166,5, үхэр 75,1, тэмээ 41,7, хонь 17941,2, ямаа 1666,6 мянган толгой байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оноос 25,2 хувиар өсч 2020 оны жилийн эцсийн байдлаар 13,080,9 сая төгрөгт хүрсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 51.6 хувь буюу 6 746.5 сая төгрөг нь уул уурхай олборлох салбар, 10 хувь буюу 1 308,4 сая төгрөг нь боловсруулах салбар, 38,4 хувь буюу 5 026,0 сая төгрөг нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 1138 аж ахуйн нэгж байгаагийн 59,6 хувь буюу 678 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Үүнийг төрлөөр нь авч үзвэл: 71.6% нь аж ахуйн нэгж, 12.3% нь төрийн бус байгууллага, 16.1% нь төсвийн байгууллага байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг ангилж үзвэл төсвийн байгууллага 140, төрийн бус байгууллага 82, компани 381, хоршоо 47, нөхөрлөл 9, Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 19 байна.

2020 онд Нийгмийн халамжийн сангаас 2022 иргэнд 7027 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон. Үүнээс нийгмийн халамжийн тэтгэмжийг 2242 иргэнд, халамжийн тэтгэвэрийг 837 иргэнд, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1472 иргэнд олгосон бөгөөд нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусlamжид 11758 иргэнийг хамруулж 2657,3 сая төгрөг олгосноос, 4558 ахмад настан, 627 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүний хөгжлийн индекс 2016 онд 0,668 байсан бол 2019 онд 0,689 болж өссөн бөгөөд нийслэл хот, 21 аймгаас 8 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр 2019 онд 18 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2020 онд өрсөлдөх чадвараараа 16-д эрэмбэлэгдсэн байна.

## МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандат нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллагад хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээнд алсын хараа, эрхэм зорилгыг тодорхойлох ажлын хүрээг тогтооно гэсний дагуу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Олон Улсын гэрээ конвенцоор тухайн салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллагад хуулиар олгосон чиг үүргийг хамруулан үзэж:

Чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг тодорхойлох хүрээнд 10 ерөнхий чиг үүрэг, 42 үндсэн чиг үүрэг, 223 дэд чиг үүрэгт мандатын шинжилгээ хийсэн.

<b>Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо</b>		<b>192</b>
<b>Үндсэн</b>	<b>Тухайн салбарын хуулийн тоо</b>	<b>138</b>
	<b>Нийтлэг мөрддөг хуулийн тоо</b>	<b>54</b>
<b>Ерөнхий чиг үүрэг: 1.Байгалийн баялаг, байгаль орчин, аялал жуулчлал</b>		
Үндсэн чиг үүрэг: 9 Дэд чиг үүргийн тоо: 35		
<b>Үндсэн чиг үүрэг</b>	<b>Дэд чиг үүрэг</b>	<b>Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид</b>
Ашигт малтмалын хайгуул хийх, зүй зохистой ашиглах бодлого хэрэгжүүлэх	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцах	Төрийн байгууллагууд
	2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, өмчийнх нь хэлбэрийг үл харгалzan зогсоо буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;	Төрийн байгууллагууд
	3. Нутаг дэвсгэрт нь газар ашиглах, эзэмших, ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулж, гарсан зөрчлийг таслан зогсоо арга хэмжээ авах;	Төрийн байгууллагууд
	4. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгэх	Төрийн байгууллагууд
Байгаль хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	1. Байгаль орчны мэдээллийн сангийн мэдээ, баримтыг төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах	Төрийн байгууллагууд
	Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;	Төрийн байгууллагууд
	2. Байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх буюу үйл ажиллагааг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээг авах	Төрийн байгууллагууд
	3. Цөлжилтийг сааруулах үүднээс ойжуулалт, ойн зурvas байгуулах ажлыг зохион байгуулж, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх	Төрийн байгууллагууд

	4. Нутаг дэвсгэртээ ажиллах байгаль хамгаалагчдыг шаардлагатай хувцас, техник хэрэгсэл, уналгаар хангах	Төрийн байгууллагууд
Нутаг дэвсгэртээ аялал жуулчлалын бодлого хэрэгжүүлэх	1. Аялал жуулчлалын нэгдсэн бодлого, мастер төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Аялал жуулчлалын гол бүс нутгуудад орон нутгийн өмчийн болон хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих замаар үйлчилгээний чанарын стандартыг дээшлүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Жуулчдын голлон зорих газруудыг тохижуулж, эко ариун цэврийн байгууламж бүхий отоглох цэгүүдийг байгуулах	Төрийн байгууллагууд
	4. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, язгуур урлаг, өв соёлын эвент арга хэмжээ зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	5. Олон улсын үзэсгэлэнд оролцож, орон нутгаа сурталчлах	Төрийн байгууллагууд
	6. Цахим технологид суурилсан аялал жуулчлалын гадаад, дотоод сурталчилгааг өргөжүүлэх	Төрийн байгууллагууд
Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах	1. Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцлийг сайжруулж, биотехникийн арга хэмжээ авах	Төрийн байгууллагууд
	2. Тарвага нутагшуулах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	3. Аймгийн хэмжээнд амьтан, ургамлын нарийвчилсан тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн, нөөцийг тогтоох	Төрийн байгууллагууд
Нутаг дэвсгэртээ ургамал хамгаалах, хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх	1. Бэлчээр, тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд ургамал хамгааллын талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зэрчлийг арилгуулах	Төрийн байгууллагууд
	2. Ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын тархалт, олшролт, хөнөөлийн тухай төрийн захиргааны төв байгууллагад жил бүр мэдээлэх	Төрийн байгууллагууд
	3. Ургамлын хорио цээр тогтоосон үед тэмцэх арга хэмжээг орон нутгийн болон мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд иргэн, хуулийн этгээдийг дайчлан оролцуулах	Төрийн байгууллагууд
	4. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоох, цуцлах	Төрийн байгууллагууд
	5. Ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархсан болон тархаж болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх	Төрийн байгууллагууд
	1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион	Төрийн байгууллагууд

Орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	байгуулах	
	2. Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учирсан эсхүл аюул үүсэх нөхцөл бүрдсэн тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч ажиллах	Төрийн байгууллагууд
	3. Хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, хог хаягдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналт, шалгалтыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	4. Хөрс хамгаалах арга хэмжээг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэх	Төрийн байгууллагууд
Түгээмэл тархацтай ашигт малтмалын бодлого хэрэгжүүлэх	1. Ашигт малтмалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй харилцах	Төрийн байгууллагууд
	2. Ашигт малтмалын талаар мэдээллийн сан хөтлөнө	Төрийн байгууллагууд
	3. Нэлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.	Төрийн байгууллагууд
	4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих	Төрийн байгууллагууд
	5. Харьялах нутаг дэвсгэртээ түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх, ашиглуулах	Төрийн байгууллагууд
Ус, цаг уур, орчны шинжилгээний бодлого хэрэгжүүлэх	1. Аюул болон орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах	Төрийн байгууллагууд
	2. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шуурхай хангах	Төрийн байгууллагууд
Усны бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	1. Ус, усан орчинг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны барилга байгууламжийг барихтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах	Төрийн байгууллагууд
<b>Ерөнхий чиг үүрэг: 2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт</b> Үндсэн чиг үүргийн тоо-2 Дэд чиг үүргийн тоо: 20		
Барилга, хот байгуулалтын	1. Барилга байгууламжийн байршил тогтоох, газар олголт, загвар зураг батлах болон техникийн нөхцөл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээлэл түүний аюулгүй байдлыг хангах, мэдээллийн сангийн байнгын үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих	Төрийн байгууллагууд
	2. Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах	Төрийн байгууллагууд
	3. Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга	Төрийн

бодлого хэрэгжүүлэх	байгууламжийг ашиглалтад оруулах	байгууллагууд
	4. Барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх	Төрийн байгууллагууд
	5. Инженерийн шугам сүлжээний талаарх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	6. Нийтийн аж ахуйн талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	7. Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих	Төрийн байгууллагууд
	8. Нутаг дэвсгэртээ орон сууц хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөл боловсруулж, хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	9. Орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангах	Төрийн байгууллагууд
	10. Орон сууцаар хангах төрөөс баримтлаж байгаа бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	11. Тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах	Төрийн байгууллагууд
	12. Хот суурины нутаг дэвсгэрт хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бурдуулэх	Төрийн байгууллагууд
	13. Хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах	Төрийн байгууллагууд
Газрын харилцааны бодлого хэрэгжүүлэх	1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	Төрийн байгууллагууд
	2. Аймгийн газрын нэгдмэл сангийн тайланг ангилал бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийх	Төрийн байгууллагууд
	3. Газар эзэмших, ашиглахтай холбогдсон маргааныг Газрын тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх	Төрийн байгууллагууд
	4. Газрыг орон нутгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулж, хамгаалалтын дэглэж, горимийг тогтоох	Төрийн байгууллагууд
	5. Газрын бирж, лэнд менежер программ, хур системийг нэвтрүүлэх	Төрийн байгууллагууд
	6. Геодези, зураг зүйн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	7. Иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах арга хэмжээг зохион байгуулж, бүртгэлийг хөтлөх	Төрийн байгууллагууд
<b>Ерөнхий чиг үүрэг: 3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэгдсэн удирдлага</b>		
Үндсэн чиг үүргийн тоо-3 Дэд чиг үүргийн тоо: 12		

Аймгийг гадаадад төлөөлөх	1. Гадаад орны дипломат төлөөлөгчийн газартай хамтран харилцах	Төрийн байгууллагууд
	2. Гадаад улсын нийслэл, муж, хотын захиргаатай харилцах	Төрийн байгууллагууд
	3. Гадаадын иргэн, хуулийн этгээдтэй харилцах	Төрийн байгууллагууд
	4. Олон улсын байгууллагатай харилцах	Төрийн байгууллагууд
	5. Хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулах	Төрийн байгууллагууд
	6. Аймгийн төлөөлөгчдийг гадаадад ажиллуулах	Төрийн байгууллагууд
Нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хүний нөөцийг сургах, давтан сургах, мэргэшүүлэх, сонгон шалгаруулах, нийгмийн баталгааг хангах	1. Төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, нөөцийг бүрдүүлэн мэргэшсэн албан хаагчаар хангах	Төрийн байгууллагууд
	2. Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах, удирдах албан хаагчдыг манлайллыг дээшлүүлэх	Төрийн байгууллагууд
Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, Төрийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох	1. Цахим засаглал, мэдээллийн технологи, сүлжээний тасралтгүй байдлыг ханганд ажиллах	Төрийн байгууллагууд
	2. Ил тод байх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах	Төрийн байгууллагууд
	3. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
<b>Ерөнхий чиг үүрэг: 4. Нутаг дэвсгэр, хүн амын аюулгүй байдал</b> Үндсэн чиг үүргийн тоо-5 Дэд чиг үүргийн тоо: 47		
Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчлах	1. Дайчилгааны бэлтгэл хангах, цугларах, шилжүүлэх байрыг тогтоох	Төрийн байгууллагууд
	2. Дайчилгааны даалгаврыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих	Төрийн байгууллагууд
	3. Иргэнд эх оронч үзэл төлөвшүүлэх	Төрийн байгууллагууд
	4. Орон нутгийн хамгаалалтын мэдээллийн сан бүрдүүлэх	Төрийн байгууллагууд
	5. Орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, даалгаваржуулах	Төрийн байгууллагууд

	6. Орон нутгийн хамгаалалтын сургалт зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	7. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг төлөвлөх, хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	8. Цэргийн алба дүйцүүлэн хаалгах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	9. Цэргийн бүртгэл хөтлөх	Төрийн байгууллагууд
	10. Цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	11. Цэрэг татах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан, зохион байгуулах	1. Аврах анги, отряд, салбар, алба, мэргэжлийн ангийг ажлаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах	Төрийн байгууллагууд
	2. Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	3. Гамшгийн үед нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн хүч, техник хэрэгслийг дайчлан гаргах	Төрийн байгууллагууд
	4. Гамшгийн үед шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, түүнийг захиран зарцуулах;	Төрийн байгууллагууд
	5. Гамшгийн үеийн хохирлын үнэлгээ хийлгэж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;	Төрийн байгууллагууд
	6. Гамшгийн цагийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар дээд шатны байгууллагатай харилцах	Төрийн байгууллагууд
	7. Гамшиг болсон нутгийн заагийг тогтоох	Төрийн байгууллагууд
	8. Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх	Төрийн байгууллагууд
	9. Нутаг дэвсгэрийн онцлогт зохицуулан гамшгаас хамгаалах алба, штаб, мэргэжлийн ангиудыг байгуулж, тэдгээрийг гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох	Төрийн байгууллагууд
	10. Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийг байнгын бэлэн байдалд байлгах	Төрийн байгууллагууд
Мэргэжлийн хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх	1.Автозам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	Төрийн байгууллагууд
	2. Аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	Төрийн байгууллагууд
	3. Байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах	Төрийн байгууллагууд
	4. Барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих;	Төрийн байгууллагууд
	5. Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих	Төрийн байгууллагууд

	<p>6. Газрын нэгдмэл сан болон газрын хэвлийг эзэмших, ашиглах, хамгаалах болон газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>7. Нутаг дэвсгэрт нь хийж байгаа геодези, зураг зүйн ажилд хяналт тавих</p> <p>8. Соёлын хяналтыг хэрэгжүүлэх</p>	Төрийн байгууллагууд
	<p>9. Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар нь ашиглуулах, эзэмшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.</p> <p>10. Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт</p>	Төрийн байгууллагууд
	<p>11. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний стандарт, нормативын хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>12. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>13. Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналт</p>	Төрийн байгууллагууд
	<p>Хууль ёс, нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах</p> <p>1. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих</p> <p>2. Өвлөх эрхийн асуудлаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p> <p>3. Гадаадын иргэдийн хаягийн бүртгэл хөтлөх, мэдээ гаргах</p> <p>4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, хэрэгжүүлэх</p> <p>5. Иргэдийг хүлээж авах ажлыг зохион байгуулж, тэднээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх</p> <p>6. Төрийн ба төрийн бус архивын баримтад нэгдсэн тоо бүртгэл явуулахад дэмжлэг үзүүлж, зохион байгуулах, холбогдох мэдээ тайланг гаргах</p> <p>7. Тухайн нутаг дэвсгэр дэх шүүх, прокурорын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, цагдаагийн байгууллагыг удирдах</p> <p>8. Хүн ам, өрхийн бүртгэл болон түр оршин суугчийн бүртгэл хөтлөх</p> <p>9. Хууль сахиулах болон бусад байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, түүний хамтын ажиллагааг уялдуулсан зохицуулах</p> <p>10. Хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгох</p> <p>11. Хүүхдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах, хяналт тавих</p>	Төрийн байгууллагууд

	12. Хүүхэд үрчлэн авах шийдвэр гаргах	Төрийн байгууллагууд
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах	1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтарч ажиллах, дэмжлэг үзүүлэх	Төрийн байгууллагууд
<b>Ерөнхий чиг үүрэг: 5. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлт, төсөв санхүү, статистик</b> Үндсэн чиг үүргийн тоо-4 Дэд чиг үүргийн тоо: 14		
Төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	21.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.	Төрийн байгууллагууд
Төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ	21.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ: 21.3.1.мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх; 21.3.2.зорилтын биелэлтийн дүнг үнэлэх; 21.3.3.биелэлтийн үр нөлөөг үнэлэх; 21.3.4.гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх; 21.3.5.төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх; 21.3.6.биелэлтийн түвшинг үнэлэх; 21.3.7.бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.	Төрийн байгууллагууд
Нутаг дэвсгэртээ татварын бодлого хэрэгжүүлэх	21.5.Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ.	Төрийн байгууллагууд
Орон нутгийн төсвийн бодлого хэрэгжүүлэх	21.6.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутагт дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хургуулнэ.	Төрийн байгууллагууд
	1. Аймаг, сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах	Төрийн байгууллагууд
	2. Хууль тогтоомжоор орон нутагт шилжүүлсэн татвар, төлбөр, хураамжийн хувь, хэмжээг тогтоох ажлыг зохион байгуулан, өргөн мэдүүлж батлуулах	Төрийн байгууллагууд
	1. Батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлэх Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг тайлагнах,	Төрийн байгууллагууд

	батламжуулах	
	2. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулах, батлуулах	Төрийн байгууллагууд
Статистикийн бодлого, үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх	1. Албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах	Төрийн байгууллагууд
	2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор, захиргааны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.	Төрийн байгууллагууд
	3. Мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэх	Төрийн байгууллагууд
	4. Нутаг дэвсгэртээ байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа, дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих дээд шатны байгууллагад өгөх	Төрийн байгууллагууд
	5. Үндэсний статистикийн хорооноос өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах	Төрийн байгууллагууд
<b>Ерөнхий чиг үүрэг: 6. Орон нутгийн дэд бүтэц</b>		
Үндсэн чиг үүргийн тоо-3 Дэд чиг үүргийн тоо: 17		
Улс, орон нутгийн чанартай авто зам, авто замын сүлжээ	1. Улсын болон орон нутгийн чанартай авто замын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх	Төрийн байгууллагууд
	2. Улсын болон орон нутгийн чанартай авто замын санг бурдүүлэх захиран зарцуулах	Төрийн байгууллагууд
	3. Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх бодлого, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулж, хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	4. Нутаг дэвсгэрт хамаарах улсын болон орон нутгийн чанартай, тусгай зориулалтын авто зам, авто замын барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хангах	Төрийн байгууллагууд
	5. Нутаг дэвсгэрт хамаарах улсын, орон нутгийн чанартай авто замын байгууламж болон авто замыг цэвэрлэх	Төрийн байгууллагууд
	6. Орон нутгийн чанартай зам, авто замын барилга байгууламж барих, засварлах, тэмдэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	7. Улсын болон орон нутгийн чанартай замын арчилгаа, засварлах ажилд хяналт тавих	Төрийн байгууллагууд
Нутаг дэвсгэрийн автотээврийн асуудал	1. Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохицуулах, зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Нутаг дэвсгэрт автотээврийн талаар баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Орон нутагтаа техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг явуулах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд

	4. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах	Төрийн байгууллагууд
Нутаг дэвсгэрийн эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж	1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд сэргээгдэх эрчим хүч ашиглахын ач холбогдлыг сурталчлах	Төрийн байгууллагууд, Эрчим хүчний зохицуулах зөвлөл
	2. Нутаг дэвсгэрийн дулаан, цахилгааны эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	Төрийн байгууллагууд, БЗӨБЦТС ТӨХК
	3. Эрчим хүчний үүсгүүр байршуулах зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах	Төрийн байгууллагууд
	4. Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүч, ариутгах татуурга, цэвэр усны хангамжийн шугам сүлжээний хамгаалалтын зурvasын зөрчлийн хяналт	Төрийн байгууллагууд, БЗӨБЦТС ТӨХК Дундговь-Ус ОНӨҮГ
	5. Шугам сүлжээг хамгаалах хамгаалалтын зурvasын хэмжээг тогтоох /шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу/	Төрийн байгууллагууд, БЗӨБЦТС ТӨХК
	6. Эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд, БЗӨБЦТС ТӨХК

#### Ерөнхий чиг үүрэг: 7. Орон нутгийн өмчийн удирдлага

Үндсэн чиг үүргийн тоо: 3 Дэд чиг үүргийн тоо: 6

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах	1. Орон нутгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, зохион байгуулах	Төрийн байгууллагууд
Орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийг удирдлагаар хангах	1. Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөх, татан буулгах санал боловсруулж аймгийн ИТХурал болон тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг тогтоох	Төрийн байгууллагууд
Орон нутгийн өмчийн бодлого, шийдвэр хэрэгжүүлэх	1. Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийн тухай санал боловсруулж Хурлын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Төрийн байгууллагууд
	2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан ажлын дүнг Хуралд тайлагнах.	Төрийн байгууллагууд
	3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллого явуулж, дүнг ИТХурал болон тэргүүлэгчдийн, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, шаардлагатай бол зохих шийдвэр гаргуулж хэрэгжилтийг зохион байгуулах;	Төрийн байгууллагууд

#### Ерөнхий чиг үүрэг: 8. Хөдөлмөр, нийгмийн хөгжил хамгаалал

Үндсэн чиг үүргийн тоо-5 Дэд чиг үүргийн тоо: 31

Нийгмийн халамжийн үйлчилгээ	1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагсдын болон хамруулах шаардлагатай өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх	Төрийн байгууллагууд
	4. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд иргэдийг хамруулах	Төрийн байгууллагууд
Хөдөлмөр эрхлэлт	1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэх	Төрийн байгууллагууд
	2. ХАБЭА-н болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. ХАБЭА-н орон нутгийн зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах	Төрийн байгууллагууд
	4. ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
Хөдөлмөрийн харилцааг зохицуулах	1. Хөдөлмөрийн хамтын хэлэлцээр байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Хөдөлмөрийн хамтын гэрээ, хэлэлцээрийг бүртгэх, биелэлтэд хяналт тавих	Төрийн байгууллагууд
Хүн амын хөгжил, хамгаалалын асуудал	1. Ахмад настны хөгжил хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Ахмад настныг дэмжих, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах	Төрийн байгууллагууд
	3. Ахмадын ордон байгуулж ажиллуулах	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	4. Байгаль орчин, түүх, соёлын өвийг хамгаалах, эх оронч үзлийг төлөвшүүлэх, ардын урлаг, ёс заншил, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд залуучуудын оролцоог хангах, дэмжих	Төрийн байгууллагууд
	5. Гэр бүлийн хөгжил хамгаалалын үйл ажиллагаа зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	6. Залуучуудын авьяас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, соёл, спортын арга хэмжээнд залуучууд оролцох, эдгээр арга хэмжээг зохион байгуулсан хуулийн этгээдийг дэмжих	Төрийн байгууллагууд
	7. Залуучуудын дунд гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэх, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх,	Төрийн байгууллагууд

	сурталчлах үйл ажиллагааг дэмжих	
	8. Залуучуудын хөгжил хамгаалалын үйл ажиллагааг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	9. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлэн ажиллах, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих	Төрийн байгууллагууд
	10. Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн дэд бүтцийг шинээр барьж байгуулах, өргөтгөх төсөл, арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	11. Сайн дурын болон хүмүүнлэгийн ажилд оролцсон залуучууд болон залуучуудын иргэний нийгмийн байгууллагын гаргасан санаачлага, сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	Төрийн байгууллагууд
	12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллах, амьдрах, сурах орчныг бүрдүүлэх, сурах, хөгжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	Төрийн байгууллагууд
	13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний салбар зөвлөлийг ажиллуулах	Төрийн байгууллагууд
	14. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөнгөлөлт, тусламж үзүүлэх	Төрийн байгууллагууд
	15. Хөгжлийн бэрхшээлтэй хүний бүртгэлийг хөтлөх	Төрийн байгууллагууд
	16. Хүүхдийн эрх, хөгжил хамгаалалын үйл ажиллагааг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	17. Хүүхдийн эрхийг хангах талаархи салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Хүүхдийн төлөө зөвлөлийг Засаг дарга тэргүүлэн ажиллах	Төрийн байгууллагууд
	18. Хүүхдийн эрхийг хангах үйл ажиллагаанд шаардагдах төсвийг батлуулж, хэрэгжүүлэх, тайлagnаж, олон нийтэд мэдээлэх	Төрийн байгууллагууд

#### Ерөнхий чиг үүрэг: 9. Хүн амын нийгэм-соёлын үйлчилгээ

Үндсэн чиг үүргийн тоо-7 Дэд чиг үүргийн тоо: 20

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх	1. Иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	2. Өсвөр үеийн шигшээ багт дэмжлэг үзүүлэх	АЗДТГ
	3. Спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах	Төрийн болон төрийн бус байгууллагууд
Орон нутагт инновацийг хөгжүүлэх	1. Инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх үүрэгтэй орон нутгийн өмчтэй болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулж ажиллуулах	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	2. Хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацийн төсөл хэрэгжүүлж, инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд
Орон нутгийн	1. Жендерийн сургалт, гэгээрлийн ажил	Төрийн болон

хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах	явуулах	төрийн бус байгууллагууд
	2. Орон нутгийн хөгжлийн бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөлд жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйг нэвтрүүлэх	Төрийн байгууллагууд
Соёл, урлагийг хөгжүүлэх	1. Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг хамгаалах, сэргээн засварлах, баяжуулах, иргэдийг номын сангийн үйлчилгээнд өргөн хамруулах арга хэмжээг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	2. Орон нутгийн соёлын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Угийн бичиг хөтлөх, монгол бичиг сурх ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	4. Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
Соёлын өвийг хамгаалах	1. Палеонтологи, археологийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага, багт дэмжлэг үзүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Соёлын өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, хадгалан хамгаалах	Төрийн байгууллагууд
	4. Соёлын өвийн судалгаа, тайлан мэдээллийг зохих журмын дагуу гаргаж, мэдээллийн санд хүргүүлэх	Төрийн байгууллагууд
Хүн амд боловсролын үйлчилгээ үзүүлэх	1. Иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Орон нутгийн боловролын сургалтын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	3. Сургалтын орчин нөхцлийг сайжруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Төрийн байгууллагууд
	4. Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурх бичиг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
	5. Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах	Төрийн байгууллагууд
Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих	1. Донорын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Төрийн байгууллагууд
	2. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлагаар хангах	Төрийн байгууллагууд
	3. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагыг шаардлагатай боловсон хүчин, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжүүлэх	Төрийн байгууллагууд
	4. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой байршуулах	Төрийн байгууллагууд
	5. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангуулах	Төрийн байгууллагууд

**Ерөнхий чиг үүрэг: 10. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ**

Үндсэн чиг үүргийн тоо-4 Дэд чиг үүргийн тоо: 21

Газар тариалангийн үйлдвэрлэл	1. Газар тариалангийн үйлдвэрлэлийг төлөвлөх, хэрэгжүүлэх, дэмжих, санхүүжүүлэх	Төрийн байгууллагууд, хувийн хэвшил
	2. Газар тариалангийн талбайг зохистой ашиглах, хамгаалах	Төрийн байгууллагууд, хувийн хэвшил
	3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн санг эрхлэн хөтлөх	Төрийн байгууллагууд, хувийн хэвшил
	4. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл хангамж, хүлэмж агуулах зоорийн ашиглалтыг сайжруулах, нэмэгдүүлэх	Төрийн байгууллагууд, хувийн хэвшил
Мал аж ахуйн үйлдвэрлэл, мал эмнэлэг, малын генетик	1. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлнэ.	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	2. Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, малын тэжээл, усан хангамжийн нөөц бүрдүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	3. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг төлөвлөх, бүртгэлжүүлэх, үржил селекци, технологийн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	4. Уур амьсгалын өөрчлөлт, гэнэтийн аюул, эрсдэлийн нөлөөллийг бууруулж, малын эрүүл мэндийг хамгаалах	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	5. Малыг ялган тэмдэглэх, малын удам зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	6. Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	7. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангах зохицуулалт, хяналтын асуудлыг сайжруулах	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	8. Халдварт болон гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаа, хэрэгжүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
	9. Шимэгчтэх өвчинөөс эмчлэн сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд, холбоод
Үйлдвэрлэл, худалдаа,	1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, хороодын судалгаа, бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	2. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хороодод санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд

үйлчилгээ	3. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, хоршоодын борлуулалтыг дэмжих	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	4. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний гарааны бизнес, техник, технологи, инновацийн кластерыг дэмжих	Төрийн болон төрийн бус байгууллагууд
	5. Жижиг, дунд үйлдвэрийн бизнес инкубац, бизнес болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт, менежментийг дэмжин хөгжүүлэх	Төрийн болон төрийн бус байгууллагууд
Хүнсний хангамж	1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх асуудлыг зохицуулах, үйлдвэрлэлд хяналт тавих	Төрийн байгууллагууд
	2. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, зарцуулах	Төрийн байгууллагууд
	3. Хүнс үйлдвэрлэлд зохистой дадал, худалдаа, үйлчилгээний стандартыг хангуулах, дэмжлэг узүүлэх	Төрийн байгууллагууд

## АЛСЫН ХАРАА

ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭН, АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛСАН БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ **АЙМАГ** БОЛНО.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

ТӨР ИРГЭН ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНД ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАН ХҮН АМЫН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙГАЛИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАНА.

## СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

СТРАТЕГИ ЗОРИЛГО: НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАН ИРГЭДИЙН ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ, ТААТАЙ ОРЧИНД АЖИЛЛАЖ, АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКС 2019 ОНД 0.689 БАЙГААГ 2024 ОНД 0.719 ХҮРГЭНЭ.

## ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, байгууллага нь бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, хуулиар ногдуулсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилтыг хэрэгжүүлэх боломжийг гадаад ба дотоод орчны хүчин зүйлийн хүрээнд тулгуурлан Гадаад орчны шинжилгээгээр улс төр, эдийн засаг, нийгэм соёл, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлж ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргасан Дотоод орчны шинжилгээгээр салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, соёл, нөөц (хүн, санхүү, техник, мэдээлэл) хийгээд технологийн үйл явц зэрэг хүчин зүйлийн хүрээнд давуу ба сул талыг тодорхойлж аймгийн Стратеги төлөвлөгөөний 55 зорилтод аймгийн ЗДТГ-ын 6 хэлтэс, Засаг даргын эрхлэх хүрээний холбогдох агентлагууд гадаад, дотоод орчны шинжилгээг хийсэн.

1. Төв суурин газрын орчны бохирдлын хэмжээг 4 хувиар бууруулах зорилтын хүрээнд хийсэн.

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
